



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 71

Номгон

**“Баянхонгор-Тохижилт үйлчилгээ”
ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Прадо автомашиныг худалдах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1998 онд үйлдвэрлэгдсэн 2007 онд Монгол улсад орж ирсэн сумын Засаг даргын Тамгын газарт ашиглагдаж байгаад 2014 онд балансаас балансад шилжүүлэн авсан 20,0 сая төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн Прадо 65-41БНХ улсын дугаартай автомашины худалдах доод үнийг 1,0 нэг сая төгрөгөөр тогтоосугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1 Автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 11⁰⁰ цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дансанд төвлөрүүлэх;

2.2 Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 08 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР